



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/19/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Эрдэнэтуяа Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бүрэлтэн гудамж-1,14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 49000,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим хуудал: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.gov.mn

ААН 02.15 № 132

Төхөөрөмж _____ -ны № _____ -т

"ДАРХАН ОРОН НУТГИЙН ЗАМ
ТЭЭВЭР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
ДАМГАЛАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан орон нутгийн зам тээвэр" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан орон нутгийн зам тээвэр" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдах байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайланг хугацаанд Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01А/99 тоот захирамжаар 35,069.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар 05 өдрийн 37 тоот тогтоолоор 93,870.1 мянган төгрөгийн авто зам, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01А/99 тоот албан бичгээр 2,606,376.8 мянган төгрөгийн авто зам буюу нийт 2,735,315.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоон 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн адийн зэсгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МАНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,424,020.04	23,101,216.90
1.1.2	Дансны авлага	9,343,316.12	1,662,627.53
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	113,544,959.14	105,376,357.11
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо/	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	137,312,295.30	130,140,201.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	77,332,635,714.99	73,386,121,273.80
1.2.2	Биет бус хөрөнгө	2,877,855.73	2,652,995.77
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	77,335,513,570.72	73,388,774,269.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	77,472,825,866.02	73,518,914,471.11
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	7,728,821.06	4,801,238.36
2.1.1.4	НДШ-ийн өр		1,946,758.78
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр	34,458.51	116,383.49
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,763,279.57	6,864,380.63
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,763,279.57	6,864,380.63
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	22,471,303,981.29	22,471,303,981.29
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,905,686,103.25	14,905,686,103.25
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	62,736,523,962.50	65,471,839,960.50
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(22,648,451,460.59)	(29,336,779,954.56)
2.3.11	Эздийн өмчийн дүн	77,465,062,586.45	73,512,050,090.48
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	77,472,825,866.02	73,518,914,471.11

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Д/д	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	500,672,978.44	581,636,302.21
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	500,672,978.44	581,636,302.21
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого	89,542,825.89	
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,684,069,930.92	6,884,269,515.01
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	153,036,019.74	385,695,281.17
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(5,246,890,146.33)	(6,688,328,493.97)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(5,246,890,146.33)	(6,688,328,493.97)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(5,246,890,146.33)	(6,688,328,493.97)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(5,246,890,146.33)	(6,688,328,493.97)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	35,064,157,802.50	(17,401,561,314.26)	55,039,586,572.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	35,064,157,802.50	(17,401,561,314.26)	55,039,586,572.78
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(5,246,890,146.33)	(5,246,890,146.33)
Өмчид гарсан өөрчлөлт			27,672,366,160.00		27,672,366,160.00
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	62,736,523,962.50	(22,648,451,460.59)	77,465,062,586.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	62,736,523,962.50	(22,648,451,460.59)	77,465,062,586.45
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,688,328,493.97)	(6,688,328,493.97)
Өмчид гарсан өөрчлөлт			2,735,315,998.00		2,735,315,998.00
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	65,471,839,960.50	(29,336,779,954.56)	73,512,050,090.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	761,208,625.96	845,372,493.98
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	408,545,454.55	580,311,661.30
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	352,663,171.41	265,060,832.68
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	758,159,716.39	831,432,842.58
	Ажиллагчдад төлсөн	144,699,940.59	182,861,846.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,399,951.19	49,331,079.63
	Бараа материал худалдан авахад төлсөн	492,889,354.32	496,376,499.34
	Ашиглалтын зардалд төлсөн	2,701,639.11	2,591,564.96
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	61,377,289.16	83,927,057.98
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	15,091,542.02	16,344,794.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,048,909.57	13,939,651.40
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		(5,262,454.54)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(5,262,454.54)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(5,262,454.54)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>3,048,909.57</u>	<u>8,677,196.86</u>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,375,110.47	14,424,020.04
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,424,020.04	23,101,216.90

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	500,672.90	567,000.00	581,636.30	14,636.30	102.58
	Үүнээс: Өөрийн орлого	м/төг	500,672.90	567,000.00	581,636.30	14,636.30	102.58
3	Нийт зардал	м/төг	502,162.20	567,000.00	7,269,964.80	6,702,964.80	1,282.18
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	502,162.20	567,000.00	7,269,964.80	6,702,964.80	1,282.18
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	(1,489.30)	-	(6,688,328.50)		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,822.6 мянган төгрөгийн алдаа зөрчил¹ илэрснээс 830.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,992.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тус газрын дарга асан Ж.Дорждэрэмийг ажлаас чөлөөлөхдөө ээлжийн амралтын цалинг 830.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “Улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж²

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

- Тус байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос Төрийн санд төвлөрүүлж байгаа 32,917.2 мянган төгрөгийн орлогоос НӨАТ-ыг суутгаж тооцолгүй татварын өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа нь “Нягтланг бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20-р зүйлийн 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид үйл ажиллагааны орлогоос тухай бүр НӨАТ тооцож, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² 20.5.Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тус газрын дарга асан Ж.Дорждэрэмийг ажлаас халагдахад амралтыг 830.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.	1	830.1	1	830.1									
Тус байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос Төрийн санд төвлөрүүлж байгаа 32,917.2 мянган төгрөгийн орлогоос НӨАТ-ыг суутгаж тооцохгүй нь татварын өр төлбөрийг нэмэгдүүлсэн байна.	1	2,992.5					1	2,992.5					
Дүн	2	3,822.6	1	830.1			1	2,992.5					

